

## ХАДЛАН БЭЛТГЭЖ ИРСЭН МОНГОЛЧУУДЫН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛААС

Л. Чулуунбаатар

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим

**Өгүүллийн товч утга:** Энэ өгүүлэлд хадлангийн тухай ойлголт, монголчууд мал сүрэгтээ хадлан бэлтгэх зайлшгүй шаардлага гарсан болон хадлан бэлтгэж ирсэн түүхэн уламжлалаас товч авч үзэв. Ялангуяа социализмын үед хадлан тэжээл бэлтгэх үйлс бүх нийтийн үйл хэрэг болж байсны ач холбогдол, түүний туршлага сургамжийн тухайд өгүүлж, өнөөгийн бодит байдалд шүүмжлэлтэй хандсаны зэрэгцээ ойрын ирээдүйг зурвас төсөөлөхийг оролдов.

**Түлхүүр үг:** Мал, өвс ургамал, бэлтгэл, өв уламжлал, сургамж

Өнөөгийн дэлхий дахинд цаг уурын дулаарал, хүний буруутай үйл ажиллагааны үр дагавраар байгаль, газар орон, ус, цаг уурт үлэмж их өөрчлөлт гарч байгаагийн улмаас байгалийн нөхцөл байнга хувьсан, олон газар оронд газрын доройтол гүнзгийрч, хөрсний үржил шим ихээхэн муудсан байна. Энэ нь бэлчээрийн мал аж ахуй эрхлэхэд хамгийн гол хүндрэлийг бий болгож, малчдын хувьд хадлан гэдэг ойлголт бараг мартагдахад хүрч байна гэхэд нэг их хилсдэхгүй болжээ. Гэвч манай орны бэлчээрийн мал аж ахуйг эрхлэн хөтлөх системийг өөрчлөөгүй нөхцөлд байгалийн бэлэн өвс ургамлыг малаараа дамжуулан ашиглах явдал хэвээр байх нь ойлгомжтой. Иймээс мал сүргийг тарга хүч сайн авахуулахын тулд уламжлалт хадлан бэлтгэлийг орхигдуулж болохгүй билээ. Цаашид уг асуудлыг хэрхэн шийдэх бэ?

Монгол хэлний товч тайлбар тольд, **хадлан** гэдгийг хадаж авах өвстэй газар: мөн өвс нь: айлын хадлан, хадланд гарах, хадлан авах, хадлан хураах, хадлангийн газар, хадлангийн машин багаж хэрэгсэл ( 1: 641 ) хэмээн бичжээ. Энд гол нь хадсан өвс гэсэн үндсэн утга агуулагдаж байна. Мал сүргийг өсгөх үндсэн нөхцөл болсон байгалийн бэлчээрийн бэлэн өвс ургамлыг зориуд хадаж хураах гол шалтгаан нь жилийн цаг улирал, ган зуд зэрэг байгалийн гамшигт үзэгдлийг даван туулах, ард иргэдийн амьжиргааны эх булаг гэгдсэн малаа он мэнд оруулах зорилготой холбоотой билээ. Гэвч монголын байгалийн бүс, бүслүүр тус бүрт хадлан авах боломж тэр бүр байхгүй, өвс ургамлын ургалт, шимт чанар ч харилцан адилгүй юм. Хадлан бэлтгэж ирсэн түүхээс цухас дурдвал, XIX зууны үеэс холбогдож байна. Энэ нь хэд, хэдэн учир шалтгаантай. Юуны өмнө хадлан бэлтгэхэд хүн хүч, өвс ургамлын байдал гол нөлөөлдөг ажээ. Баримт нягтлан үзвээс, 1822 онд АНУ-ын зохион бүтээгч Бейли өвс хадагч машиныг анх хийжээ. Энэ нь мал сүргээ тэжээх нөөц эх булагтай болох гол зорилготой холбоотой байсан уу, эсвэл өөр шалтгаантай уу. 1831 онд мөн АНУ-ын Мак Кормик тариа хадах машиныг зохион бүтээжээ. Энэ бүхэн нь хөдөө аж ахуйн техник тоног төхөөрөмж улам боловсронгуй болж, төрөл зүйл нь өргөжих үндэс суурийг тавьсан бөгөөд газар тариалангийн үйлдвэрлэл ихээхэн хөгжиж дэвших үндсэн нөхцлийг бүрдүүлжээ. Үйлдвэрлэлийн ийм багаж хэрэгсэл зохион

## II МОНГОЛЫН ТҮҮХИЙН ДУНДАТ ҮЕИЙН АСУУДАЛ

бүтээгдсэн н цаашид гар ажиллагааг хөнгөвчилөх механик тоног төхөөрөмж хийгдэх боломж олгосон болстой. Монголчууд гараар өвс хадах хэрэгслийг шимээскэ ( гар хадуур) гэж нэрлэж заншсан нь үүнийг анх хийсэн Шмейско хэмээх орос хүний нэртэй холбоотой юм. Бас өвс хадах моринкадуурыг хүмүүс косилка гэж нэрлэдэг. Тиймээс яагаад орос хүний хийсэн багаж хэрэгслээр монголчууд хадлан хадаж байсан бэ гэсэн асуудал гарч байна. Энэ бол бүр XIX зууны үеэс убаатай ажээ.

Байгаийн хатуу ширүүн үзэгдлийг гэтлэн давахад хадлан өвс бэлтгэж ашиглах явдал XIX зууны үеэс зарим орон нутаг ( Түшээт хан, Сэцэн хан аймгийн зарим хошуу )- нд дэлгэрч эхэлсэн байн. 1890 онд Хүрээний сайдын газраас зуд гачиг тохиолдвол малыг тэжээхийн тулд өвс хадаж бэлтгэсэн тухай жил бүрийн эцэст мэдүүлж байхыг тушааж байжээ. 1895 онд Сэцэн хан аймгийн 21 хошуу өвс хадаж бэлтгэсэн ажээ. Өвсийг эхлээд гар хадуураар хадаж, модон савар тармураар хурааж байснаа улмаар өвс хадах морин машин, тармуур хэрэглэх болж, голчлон Төв Сэлэнгэ, Булган, Хэнтий, Дорнод зэрэг аймгийн зарим ардын аж ахуйтнууд тэдгээр машиныг худалдан авч ашиглах болжээ.

Мал сргийг онд мэнд оруулах тэжээлийн үндсэн бааз бий болгох зорилгоор 1937 оноос ЗХУ-ын тусламжтайгаар өвс хадах морин станц байгуулагдсанаар ургац арвинтай унац сайтай хангай хээрийн зарим нутагт хадланг их хэмжээгээр бэлтгэж байв. ( 2: 153, 72 ) Тухайн үед манжийн шинэ засгийн бодлого гэгч хэрэгжиж, монголын ард түмний ахуй амьдрал ихээхэн ядуурч, байлц цаг уурын хүндрэл бэрхшээл ард олны аж ахуйд үлэмж хохирол учруулж байжээ. Мөн монгол, оросын хил орчмын ард иргэд найрсаг харилцаж, бие биеэсээ их зүйлийг сурч хамтраажиллаж ирсэн сайхан уламжлалтай юм. Тийм ч учраас хил орчмын монголчууд бүр XVII зуны үеэс оросуудтай харилцаж, тэднээс багагүй зүйлийг сурч, амьдрал ахуйдаа хэрэглэж ирээ. Энэ уламжлал нь XIX зууны үе болоход улам ч өргөжиж, хадлан тэжээл бэлтгэх явда зарим орон нутагт явагдаж байв.

- Монгол орноор аялан явж байсан хүмүүсийн тэмдэглэл болон оросын худалдааны экспедицийн тайланд, монгол орны байгаль цаг уурын нөхцөл, нүүдлийн мал аж ахуй, түүнийг эрхлэн хөтлөх арга технологийг товч бичсэн, бас монгол дахь оросуудын үйл ажиллагааны талаар дурдсан зүйл цөөнгүй тааралддаг. Тухайлбал, оросын академич И. М. Майский (3), А. В. Бурдуков (4), Болобаны экспедицийн тайлан (5), М. И. Боголепов, М. Н. Соболев (6), “Современна Монголия” цуврал (7) зэрэгт монголд амьдарч байсан оросууд мал худалдаж авах, өвс хадх, мод бэлтгэх, төмс хүнсний ногоо тарих гэх мэт аж ахуйн үйл ажиллагаа явуулж ирснийг баримттайгаар бичжээ.

Түүнчлэн 1930-аад оны үед монголын шинжлэх ухааны хүрээлэнгээс “ зэргэлдээ буюу төрөл болохбуриад, хасаг, барга, цахар зэргийн зарим гадаад улсын маллагааны зүйлийг бүртгэн бичүүлж” (8: 2), Цахарын мал аж ахуйн тэмдэглэлийг Б.Буянчуулган нийтлүүлжээ. Уг тэмдэглэлд, “Цахар болбаас, баян үгээгүйн байдалд нийлүүлэн тус тус хадлангийн газар хуваан

олгомой. Үүнээс гадна өвөлжөөний газрыг өөр өөрөөн эзэлмүй. Ханш орсны хойно үхэр хонины хар бууц, тэжээсэн морины өвс лүгээ холилдсон морины баас шээстэй хогийг тээн аваачиж хадлангийн газар сацаж бордмой. Тариалангийн хур хэмээх улирал болмогц усалмой. Зуны уур орсны хойно, хадлангийн газар ба өвөлжөөний газарт мал оруулахыг цээрлэмүй. Бороо ховор жилд хадлангийн газрыг нар буцсаны хойно дахин нэг удаа усалмой. Бороо элбэг жилд, их халууны улирлын үед үерээс хамгаалж шавар шороогоор өчүүхэн хашлага хиймүй. Хэрэв өндөр ургасан өвс үерт дайрагдваас унаж, хадахад үл болохын дээр, тэрхүү унасан өвс шавар лугаа холицолдон мал үл идэхэд эсэрхүү жил хадлангийн өвс хуучин цагаан өвстэй болж хадахад бэрх, мал тэжээхэд бас ч шим муу болохын тул хэрэв иймд хүрвээс, хавар цаг ногоо ургахын урьд гал тавьж шатаамой. Үүнд түймэр болохыг цагдан сэргийлэх бөгөөд, албаны газарт мэдүүлж зөвшөөрлийг олгосны хойно сая гүйцэтгэмүй. Бас өвөлжөө хадлангийн газар, он удаж шим муудснаар бүдүүн муу өвс ургах нь болбаас, бас ч гал тавьж шатаамой. Энэ нь газрын хөрс сул болон муудаж, шимтэй газарт нарны илч нэвтрэн хүрэхгүй буюу, муу хүрснээс ургасан нь, бүдүүн муу өвс болох тул, тийнхүү гал тавьж шатааваас муу өвсний үндэс нь үхэж, сайн хөрсөнд галын илч хүрснээр шимтэй нарийн өвс ургамой. Сэрүүний цаг хэмээх улирал болмогц ногоонд будаг суумой. Шүүдрийн өнгө цайвар болмой. Даруй хадланг эхлэн хадмой. Хадсан өвсийг өдөр тутамд бухалдаж овоолмой. Бороо тохиолвдоос үл хадмой. Хадлангийн өвсийг хадсан даруй овоолбоос, шим нь нар салхинд үл хувирмой. Бороо оровч энэ үед нарны илч бухалтай өвсөнд нэвтрэх авч, халууны улирал буурсан бөгөөд шөнөд мөн бухалтай өвсөнд мөн хүйтний хүч нэвтрэх тул хэрхэвч гэм болохгүй, бороонд хадсан ба задгайгаар норж овоолсон өвс шим муу болохын дээр өөрийн чийг, борооны чийг лүгээ харшилдаж даруй ялзармой. Өдөр шөнө тэнцэхийн урьд хадланг хадаж дуусгамой. Энэхүү хадсан газарт хэнз ногоо ургамой. Үүнээс хойно болбаас, өвсний өнгө хувирч шим бага болмой. Цагаан шүүдэр хэмээх улирал орсны хойно бухалтай өвсийг тээн аваачиж, өвөлжөөний газарт нуруу болгон хураамой. Энэ үесд малыг хадлангийн газар бэлчээрлүүлмэй.” (9: 19- 21) гэжээ. Энэхүү тэмдэглэлээс үзэхэд, өнөөгийн өвөр монголын нутаг дэвсгэрт хадлан авч байсан туршлагаас нэлээд тодорхой бичжээ. Зарим арга технологи нь монгол малчдынхтай ойролцоо боловч бас ялгагдах зүйл их байна. Өнөө үед бэлчээрийн талбай зэрлэг өвсөнд баригдсан тул хэдэн жил өнжин сайн өвс ургамал ургахыг хүлээх үү, эсвэл өвөрлөгч нарын туршлагаар гал тавьж, хөрсөнд органик бордоо нэмэрлэх замаар өвс ургамлын зүйлийн бүрэлдэхүүнийг сайжруулах уу гэсэн асуудал зүй ёсоор урган гарч байна.

Ер нь “ нарны энергийг шингээсэн тал нутгийн ургамал бүхэлдээ амьтны тэжээл болж чаддаггүй, хагас орчим нь хагд болон хөрсөнд шингэдэг. Хатсан ургамал хэдэн жилээр хадгалагдах биш бага багаар ялзран задарч байдаг нь хөрсний шимэгчид болон бактерийн идэвхжилтэй холбоотой. Хөрсний шимэгчид гэдэг нь хөрсөнд амьдардаг чийгийн улаан хорхой, шавьжны төрлийн бусад амьтад байх бөгөөд тэд ялзарсан ургамал, амьтдыг идэж амьдарна. Хөрсний амьд биетүүд нь ялзмагийн хэсэг бөгөөд “ талын цэвэрлэгч “ гэж нэрлэгддэг. Хөрсний амьд биетүүдийн томоохон биетэй хэсэг болох шавьж, нисдэг хорхой нь

## II МОНГОЛЫН ТҮҮХИЙН ДУНДАТ ҮЕИЙН АСУУДАЛ

хааяагүй элбэг далавчит төрөл ба хар хорхойн төрөл нь ялгасны орчим бөөгнөрч амьдарна. Ялгас нь органик биш элемент болоход амархан бөгөөд бактери мөөгөнцөр мэтийн микроорганизмаар органик биш элемент болж хөрсөнд шингэдэг.” ( 10: 131 ) ажээ. Энэхүү хагдыг монголчууд **хөх, хар бог** гэдэг. Тийм ч учраас монголчууд “ хүн төрвөл нэгэн үе, өвс ургавал нэгэн намар “ гэж ярьдаг. Хавар ургасан өвс ногоо нар хурны үйлчлэлээр улам өтгөрч, шимт чанар нь сайжраад, намар толгой нь хүрэнгэн, улмаар шарлаж хатах үе шатандаа шилждэг. Шарлан хатсан өвс ургамал цайж, салхины хүчэнд зарим хэсэг нь газар унаж, жил өнжиж ирэхэд хөхөрдөг. Түүнийг **хөх бог** хэмээнэ. Тэр хөх богоос зарим хэсэг нь ус чийгний улмаас харлан ялзарч, газрын хөрсөнд шингэн бордооны үүрэг гүйцэтгэдэг билээ. Дараа жилийн хавар шинэ өвс ногоо ургахад мал түүнийг өмнөх жилийн хөх богтой хамт иддэг. Түүнийг монголчууд **хоолт бог** гэдэг. Тэдгээр нь цаашдаа хар бог болон хөрсний үржил шимийг тэтгэгч бордооны үүргийг гүйцэтгэх зүй тогтолтой ажээ. Энэ зүй тогтлыг монголчууд, түүний дотор хадланчид сайн мэдэж, ургац сайтай, унац арвин газар нутгийг сонгон өвс хадлан бэлтгэж ирсэн нь бүр эртний уламжлалтай байна.

Хуучин социализмын үед мал аж ахуйн материаллаг баазыг бэхжүүлэх асуудал онцгой анхаарал татаж, хадлан бэлтгэх ажилд бүх нийтээрээ оролцож байв. Ялангуяа хөдөө аж ахуйн нэгдлийн үед малчин өрх бүр хадлан тэжээл бэлтгэхэд гар бие оролцож, улсын хөрөнгө оруулалттай отор тэжээлийн аж ахуй, хадлангийн механикжсан салаанууд аймаг орон нутаг төдийгүй, улсын аюулаас хамгаалах фондод асар их хэмжээний өвс хадлан бэлтгэж иржээ. Тэр үед бэлчээрийн өвс ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, ургалт, унац, шимт чанар ч гойд сайн байсан тухай ахмадууд дурсан ярьдаг. Бүр 1930-аад оны үеийн өвс хадах морин станцаас эхлээд Мал аж ахуйн машинт станц, улмаар хадлангийн механикжсан салаанууд, нэгдлийн бригад тус бүр хадлан бэлтгэх улсын төлөвлөгөөг биелүүлэхийн төлөө жил бүрийн намар нөр их ажил өрнүүлдэг уламжлалтай байсан билээ. “Манайд бэлтгэж байгаа тэжээлийн ихэнхийг байгалийн хадлангийн өвс эзэлнэ. ХААЯ-ны газар зохион байгуулах экспедицийн тогтоосноор нийт 1,2 сая тонн өвсний нөөцтэй 1,9 сая га хадлангийн талбай байна. Хадлангийн бүх талбайг ургамлын бүрэлдэхүүн, байгаль- газар зүйн байршил зэргийг харгалзан экологийн 8 үндсэн бүлэгт хуваана. Үүнд: 1. Хуурай хээрийн хадлан. 2. Хээрийн хадлан. 3. Уулын- хээрийн хадлан. 4. Уулын нуга- хээрийн хадлан. 5. Уулын нугын хадлан. 6. Эх газрын нугын хадлан. 7. Голын дэнж, нуга, нуурын орчмын хадлан. 8. Халилгын нугын ба усалгаатай хадлан “ (11: 50- 51) гэж бичжээ. Бэлчээрийн өвс ургамал өтгөн сахлаг, үржил шим сайтай газарт жил бүр хадлан бэлтгэхдээ технологийн нарийн арга ажиллагааг мөрддөг байсан бөгөөд хадах, тармах, боох буюу бухалдах, нуруулдах ажиллагааг өвсний чийгтэй холбож, 55 орчим хувийн чийгтэйд нь тармаж, мөрлөсөн өвсийг хурдан хатаах зорилгоор тармаснаас хойш 2- 3 цагийн дараа эргүүлж задгай өвс бэлтгэдэг ажээ. Задгай өвс бэлтгэхдээ 35- 40 хувийн чийгтэй өвсийг бухалдана. Бухлаа зөөж нуруулдах үед ус тогтохгүй, өндөрлөг газрыг сонгож, өндөр шовхдуу оройтойгоор нуруугаа хийдэг. Манай орон нутаг бүрт хадлан бэлтгэх арга ажиллагаа харилцан адилгүй юм. Гол төлөв хангай нутагт өвсөн мушгиа хийж, витаминт ногоон өвсний шимийг алдагдуулахгүй

хадгалдаг аргатай байна. Бас ногоон ургамлын шимт бодис, витаминьг алдагдал багатайгаар хураан авах аргын нэг нь өвсөн дарш бэлтгэж хэрэглэх арга юм. Хадсан ногооны чийгийг 55 хувь болмогц 3- 5 см урт хэрчиж даршны нүхэнд жигд зулж, трактораар гишгүүлж нягтруулна. Даршны нүх дүүрмэгц ногоон өвсөөр 20- 30 см зузаан бүтээж, дээр нь нийлэг хальс тавьж сүрэл, боосон өвсөөр 0,5- 1,0 м зузаан хучна. Энэ бол өвс ургамал, түүний шимт чанар нь сайн байсан үеийн арга технологи хэдий ч өнөө үед анхаарч үзүүштэй зүйл нэлээд байгаа билээ.

1950-иад оны эцэс хүртэл хадлан бэлтгэх ажлыг Мал аж ахуйн машинт станц голлон гүйцэтгэж ирсэн бол тус оронд нэгдэлжих хөдөлгөөн ялснаар хөдөө аж ахуйн нэгдлүүд, сангийн аж ахуйнууд уг үүргийг биелүүлж, улмаар отор тэжээлийн аж ахуйнууд байгуулагдан, олон аймаг орон нутагт улсын төлөвлөгөөт хадлан бэлтгэх ажил эрчимтэй явагдаж байжээ. Тэдгээр олон аж ахуйнууд, нэгдлүүдэд улсын аварга, хошой аварга хадлангийн салаанууд олноор төрж гарсны зэрэгцээ аварга хадланчид, механикжуулагчдын ажлын шилдэг туршлага нийтийн хүртээл болж байв. Урьд өмнөх үеийн хадлан бэлтгэлийн туршлага сургамжаас ажиглахул, энэ бүх нийтийн үйлсэд олон түмний хүч хөдөлмөрийг нэгтгэн өрнүүлж, их хэмжээний хадлан бэлтгэж байсан бол бас хадлангийн талбайг тордож сайжруулах, ургацыг нэмэгдүүлэх зориудын арга хэмжээ авч хэрэгжүүлсэнгүй, зарим газарт улсын фондын хадлангийн талбай, олон нуруу өвс тэжээлийг түймэрт шатаах, ялзлах, малд идүүлэх зэрэг хариуцлагагүй байдал их гаргаж байжээ.

Одоогоос хориод жилийн өмнө мал сүргийг онд мэнд оруулах нэг гол арга нь хадлан бэлтгэх явдал байсан. Тэр үед бэлчээр, хадлангийн ургацыг нэмэгдүүлэхэд чиглэсэн агро техникийн нэлээд арга хэрэглэгдэж байсны дотор тордож сайжруулах, таримал бэлчээр, хадлан бий болгох гэсэн хоёр үндсэн арга зонхилж байжээ. Бэлчээр, хадлангийн талбайг тордож сайжруулахад хамгийн гол нь цас борооны усыг ашиглах, голоос шуудуу татаж услах, өвөл ус халиаж тошин гүйлгэх, цас, мөс тогтоох зэргээр услалтын нарийн горимыг баримтлахын сацуу хонины бууц, адууны хомоолыг бордоо болгож ашиглахаас гадна зарим орон нутагт өвөл үхрийн хөлдүүсийг цуглуулж саравчны ойролцоо тарааж асгаад хавар модон булаар булдаж нунтаглаад овоолно. Ингэж бэлтгэсэн нунтаг бууцыг **урь** гэж нэрлэнэ. Урийг өвөл малд дэвсэхэд тэр нь зузаарч малын шээс шингээн хөрзөн ( шивх) болно. Үүгээр хадлан бордоно. Сүүлийн үед азот, шүвтрийн шүү, фосфор, калийн бордоо хэрэглэдэг болжээ. Таримал хадлан бий болгоход талбайг зөв сонгон, хөрс боловсруулалтыг зохих технологийн дагуу явуулж, тарих үрийн норм, хэмжээг тогтоож тариалалт хийгээд сайтар услаж, ургацын хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэн туршлага зарим орон нутагт байв. Гэвч сүүлийн 20 гаруй жилд байгаль, газар орон, ус, цаг уурын нөхцөл ихээхэн өөрчлөгдөж, манай нийгмийн үйлдвэрлэл хөдөлмөрийн зохион байгуулалт ч шинэчлэгдэн, хадлан бэлтгэх ажлын цар хүрээ ихээхэн хумигдсан байна. Харин манай мал сүргийн тоо толгой ихээхэн нэмэгдэж, 40 гаруй сая болсон, урьд өмнө малын тоо толгойг богд шилжүүлснээр 60 сая малыг бэлчээрээр маллах боломжтой гэсэн тооцоо хийгдсэн байсан бол байгалийн нөхцөл улам бүр доройтож, өвс ургамлын зүйлийн

## II МОНГОЛЫН ТҮҮХИЙН ДУНДАТ ҮЕИЙН АСУУДАЛ

бүрэлдэхүүн иээхэн ядуурч, шимт чанар нь үлэмж муудсан ажээ. Энэ бодит байдал нь цаашид хадлангийн туай асуудалд цоо шинэ хандлагаар хандахаас өөр аргагүй гэдгийг харуулж байна.

Энэ бүнээс үндэслэн, малын тэжээлийн гол хэсэг болох хадлан бэлтгэх ажлыг шинэ нөхцөлд өвөрмөц арга хэлбэрээр зохион байгуулах зайлшгүй шаардлага тулгарч байна. Юуны өмнө монголчууд эртнээс хадлан бэлтгэж ирсэн туршлага сургамжийг судлаж, ном товхимол, гарын авлага гргах нь хүүхэд залуучууд, ер нь хэн бүхэнд танин мэдэхүйн ач холбогдолтой, бас практик амьдралд тустай хэрэглэгдэхүүн болно. Социализмын үеийн төвлөрсөн төлөвлөгөөт эийн засгийн тогтолцооноос санаа сургамж авах, авч ашиглабал зохих зүйл цөөнгүй билээ. Түүний нэг нь манай ард түмэн олон үе дамжин мал сүрэгтээ арвин их хадлан тэжээл бэлтгэж ирсэн туршлага сургамж даруй мөн гэж үзүүштэй. Өнөө үед байгаль, газар орон, ус, цаг уурын эрс өөрчлөлтийн улмаас манай оронд газрын доройтол мэдэгдэхүйц нэмэгдэж, бэлчээрийн өвс ургамлын зүйлийн бүрэлдэхүүн өөрчлөгдөн, шимт чанар нь үлэмж доройтсон байа. Энэ нөхцөлд сөөм газрын атга өвс ногоо ч бараг алт лугаа адил үнэтэй болж байгааг харгалан, гар хадуур, тармуур ашиглаж, жалга судаг, нугын шимтэй өвс ургамлыг хадаж авах, тэимал өвс ургамлыг арчлан тордох, бэлчээрийн талбайг усжуулах, сайн өвс ургамалтай газыг хашиж хамгаалах, худаг, уст цэгийг нэмэгдүүлэх, гол горхи, булаг шандыг сэргээх, бага өрын техник, технологи нэвтрүүлэх, хадлан бэлтгэх ажилд олон түмний хүч анхаарлыг төвөрүүлэх зэрэг арга хэмжээг тухайн жилийн бэлчээрийн даац, нөөц, хэрэгцээ шаардлагыг үнэслэн зохион байгуулах хэрэгтэй юм. Малын тэжээлийн найдвартай баазыг бий болгож, хадланбэлтгэх, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхгүйгээр мал сүргийг цаашид өсгөх, ашиг шимийг өмэгдүүлэх ямар ч бололцоогүй билээ.

### Abstract

The haymaking is an activity which was created as a method for getting Livestock into the new year in fine fettle and using pasture resources at the end of 13 th century. During socialism the haymaking was a public activities so every aimags, sums, transhumance and feed farming had been prepared thousands ton of hay and built the the feed reserves up.

Howeve nowadays the Land degradation and fertility are causing the haymaking difficulties under the influences of the changes in environment, area and climate we have to expand the haymaking activities in new conditions mobilizing all our available resources to get our livestock into the new year in fine fettle.

Эшлэл, зүүлт

1. Я. Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь УБ, 1966
2. Ш. Нацагдорж. Халхын түүх ( хоёр дахь хэвлэл) УБ, 2008, Л. Чулуунбаатар. Бэлчээр нутаг сонгох малчдын уламжлалт арга ухаан, орчин үе ( дорнод тал хээрийн бүсийн жишээн дээр) УБ, 1993
3. И.М. Майский. Монголия накануне революции М, 1960. Современная Монголия.
4. А. В. Бурдуков. Шинэ ба хуучин монголд УБ, 1987
5. А.П. Болобан. Монголия в ее современном торгово- экономическом отношении “Московская торговая экспедиция в Монголии” СПб, 1914
6. М.И. Боголепов и М.Н. Соболев. Очерки русско- монгольской торговли. Экспедиция в Монголии в 1910 г. Т. 1, Томск, 1911
7. Симуков. Хотоны. – Современная Монголия, № 2 1933
8. Б. Буячуулган. Цахарын мал аж ахуйн тэмдэглэл - Современная Монголия, № 2, 1933
9. Мөн тэнд
10. Ким Жо Рэ, Их шуурганаар сийлэгдсэн түүх ( Нүүдэлчдийн тухай өгүүлэх нь ) УБ, 1999
11. БНМАУ-ын мал аж ахуйг хөглөх систем УБ, 1982